**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 06 сарын 12 өдөр Дугаар А/149 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн ажиллах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (бригадын генерал Г.Ариунбуян)-д даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/123 дугаар тушаалын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Т.БАДРАЛ

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2017 оны 06 дугаар сарын 12-ний өдрийн
А/149 дугаар тушаалын хавсралт

# ГАМШГИЙН ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв (цаашид “төв” гэх)-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Төв нь гамшгийн нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээлэл хүлээн авах, шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах, гамшгийн аюулыг зарлан мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

1.3. Төв нь холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, програм хангамж, сүлжээний бэлэн байдлыг хангана.

## Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

2.1. ”Шуурхай удирдлага” гэж төв, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллага, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гамшгийн нөхцөл байдлын тухай мэдээ, мэдээллийг хүлээн авч үнэлгээ, дүн шинжилгээ хийж гамшгаас хамгаалах арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг;

2.2. ’’Гамшгийн аюулын эрт зарлан мэдээллийн систем’’ гэж эрсдлийг ойлгох, зураглах, болзошгүй аюулыг хянаж шинжлэх, урьдчилан анхааруулах, иргэн, хуулийн этгээдэд зарлан мэдээллийг нэгдсэн удирдлагаар ойлгомжтой, шуурхай хүргэх, өгөгдсөн мэдээллийн дагуу хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны цогцыг;

2.3. ”Мэдээлэл хүлээн авах” гэж төв, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллага, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гамшгийн нөхцөл байдлын тухай мэдээ мэдээллийг бүртгэн авах үйл ажиллагааг;

2.4. ”Мэдээлэл дамжуулах” гэж төв, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллага, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гамшгийн нөхцөл байдлын тухай мэдээ, мэдээлэлд боловсруулалт хийж эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэхийг;

2.5. ”Гамшгийн нөхцөл байдлын хоногийн мэдээ” гэж төв, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллага, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гамшгийн нөхцөл

байдлын тухай мэдээ, мэдээллийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний явц, үр дүнг танилцуулахаар боловсруулсан цахим болон хэвлэмэл баримт бичгийг;

2.6. “Жижүүрлэлтийн үүрэг” гэж энэ журам болон Гамшгаас хамгаалах хууль тогтоомжид заасан эрх эдэлж, тусгай техник, тоног төхөөрөмж ашиглан тогтоосон цагийн хуваарийн дагуу үүрэг хүлээх алба хаагчийг хэлнэ.

## Гурав. Шуурхай удирдлага, зохицуулалтын үйл ажиллагааны зохион байгуулалт

3.1. Төв нь үүссэн болон үүсч болзошгүй гамшгийн нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээллийг хүлээн авах, бүртгэх, танилцуулах, төв, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллагыг шуурхай удирдлагаар хангах, улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах албаны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулна.

3.2. Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагааны шуурхай, найдвартай, тасралтгүй байдлыг хангах зорилгоор зарлан мэдээллийн хөдөлгөөнт удирдлагын төв, холбооны хөдөлгөөнт зангилгаатай байна.

3.3. Зарлан мэдээллийн хөдөлгөөнт удирдлагын төв, холбооны хөдөлгөөнт зангилгааг газар хөдлөлт, гал түймэр, үер зэрэг гамшигт тэсвэртэй, хоёр талын цахилгааны эх үүсвэртэй, харуул хамгаалалт бүхий дулаан тавиуланд байрлуулна.

3.4. Холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжид хийх засвар үйлчилгээг “Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийн техник, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар”-ын дагуу зохион байгуулна.

3.5. Зарлан мэдээллийн хөдөлгөөнт удирдлагын төв, холбооны хөдөлгөөнт зангилгааны автомашины засвар, техникийн үйлчилгээг хангалт, үйлчилгээ хариуцсан бүтцийн нэгж зохион байгуулна.

3.6. Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

3.6.1. гамшгийн нөхцөл байдлын тухай мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

3.6.2. гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, шуурхай удирдлага, зохицуулалт хариуцсан дэд дарга, бүтцийн нэгжийн даргад танилцуулах;

3.6.3. гамшгийн нөхцөл байдалтай холбогдуулан удирдлагаас өгсөн үүргийг төв, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллагын дарга /захирагч/ болон холбогдох албан тушаалтанд дамжуулж, хэрэгжилтэд хяналт тавих;

3.6.4. гамшгийн нөхцөл байдал үүссэн үед төв, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллагыг шуурхай удирдлагаар хангах, харилцан ажиллагааг зохицуулах;

3.6.5. улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах албаны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

3.6.6. гамшгийн зарлан мэдээлэл явуулах үүргийг техникийн бэлэн байдал хариуцсан инженер, холбоо зарлан мэдээлэл хариуцсан операторт өгөх;

3.6.7. төв, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллага, иргэн, хуулийн этгээдээс шаардлагатай мэдээ, мэдээлэл, хүч хэрэгслийн тооцоо, судалгааг гаргуулан авах;

3.6.8. гамшгийн нөхцөл байдлын талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай мэдээллийн алба, Засгийн газрын Шуурхай жижүүртэй мэдээлэл солилцох;

3.6.9. “Гамшгийн нөхцөл байдлын хоногийн мэдээ”-г баримт бичгийн стандартын дагуу боловсруулж, цахим бүртгэл, мэдээллийн нэгдсэн системд оруулах;

3.6.10. “Гамшгийн нөхцөл байдлын хоногийн мэдээ”-г Онцгой байдлын ерөнхий газрын дарга, шуурхай удирдлага, зохицуулалт хариуцсан дэд дарга, бүтцийн нэгжийн даргад танилцуулах, удирдлагаас өгсөн үүргийг холбогдох албан тушаалтанд мэдэгдэх;

3.6.11. “Гамшгийн нөхцөл байдлын хоногийн мэдээ”-г бусад албан тушаалтанд Онцгой байдлын ерөнхий газрын цахим мэдээлэл хадгалах толгой компьютер /файлсервер/-ээр дамжуулан хүргэх;

3.6.12. үүрэг гүйцэтгэх дараагийн шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчид онцлон анхаарах болон тодотгох гамшгийн нөхцөл байдал, удирдлагаас өгсөн үүргийг нэг бүрчлэн танилцуулж, энэ тухай төвийн даргад мэдэгдэх;

3.7. Техникийн бэлэн байдал хариуцсан инженер нь дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

3.7.1. холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгсэл, программ хангамж, мэдээллийн сүлжээний бэлэн байдлыг хангах;

3.7.2. зарлан мэдээллийн системд холбогдсон байгууллагаас ирүүлсэн мэдээ мэдээллийг шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчид тухай бүр танилцуулах;

3.7.3. шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн өгсөн үүрэг, баталсан хуваарь, бичвэрийн дагуу гамшгийн зарлан мэдээлэл явуулах;

3.7.4. үүрэг гүйцэтгэсэн хугацаанд хийсэн ажлын тухай мэдээг төвийн даргад биечлэн танилцуулж ажлаа хүлээлцэх;

3.8. Холбоо зарлан мэдээлэл хариуцсан оператор нь дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

3.8.1. төв, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллага болон гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа шуурхай бүлэгтэй бүх төрөл (радио, телефон, сансрын, цахим, дүрст, хөдөлгөөнт)-ийн холбоог зохион байгуулах;

3.8.2. гамшгийн нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчид шуурхай танилцуулах;

3.8.3. гамшгийн зарлан мэдээллийг шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн өгсөн үүрэг, баталсан хуваарь, бичвэрийн дагуу эфирээр нэвтрүүлэх;

3.8.4. зарлан мэдээлэл дамжуулсан тухай бүртгэл хөтлөх;

3.8.5. албан томилолтын үнэмлэх, бэлэн мөнгө, автомашины шатахууны талон, суурин болон үүрэн телефон холбооны ярианы төлбөрийн карт, сансрын холбооны утас, хэт богино долгионы гар радио станц, байршил тодорхойлогчийг "Гамшгийн голомтод болон хойшлуулшгүй яаралтай ажилд томилон ажиллуулах журам"-д заасны дагуу олгох, хүлээлцэх;

3.8.6. үүрэг гүйцэтгэсэн хугацаанд хийсэн ажлын тухай мэдээг төвийн даргад биечлэн танилцуулж ажлаа хүлээлцэх.

3.9. Мэдээ, мэдээллийг энэхүү журмын хавсралтын дагуу иргэн, хуулийн этгээдээс хүлээн авна.

3.10. Мэдээ, мэдээллийг "Хоногийн нөхцөл байдлын цахим мэдээллийн сан байгуулах, түүнийг ашиглах" зааврын дагуу боловсруулж "Цахим бүртгэл, мэдээллийн систем"-д оруулна.

Дөрөв. Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагааны зохион байгуулалт

4.1. Зарлан мэдээллийг "Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх заавар"-ын дагуу зохион байгуулна.

4.2. Гамшгийн аюулын дохиог онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр зохион байгуулна.

4.3. Гамшгийн аюулаас сэрэмжлүүлэх мэдээ мэдээллийг шуурхай удирдлага, зохицуулалт хариуцсан бүтцийн нэгжийн даргын шийдвэрээр зохион байгуулна.

4.4. Хүчтэй газар хөдлөлтийн үед зарлан мэдээллийн систем автоматаар ажиллаагүй тохиолдолд техникийн бэлэн байдал хариуцсан инженер "гар ажиллагааны горим"-оор ажиллуулна.

4.5. Төв нь газар хөдлөлт, гал түймэр, террорист халдлага, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болох программ хангамж, техникийн гэмтэл,

саатлын улмаас хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон тохиолдолд зарлан мэдээллийн хөдөлгөөнт удирдлагын төв, холбооны хөдөлгөөнт зангилг

ааг шууд ажиллагаанд оруулна.

4.6. Зарлан мэдээллийн хөдөлгөөнт удирдлагын төв, холбооны хөдөлгөөнт зангилгаа нь гамшгийн нөхцөл байдал үүссэн орон нутаг, объект, голомтын бүсэд шуурхай шилжин байрлаж үүрэг гүйцэтгэнэ.

4.7. Зарлан мэдээллийн хөдөлгөөнт удирдлагын төв, холбооны хөдөлгөөнт зангилгааг баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу сургалт, дадлагад ашиглаж болно.

## Тав. Төвийн дотоод үйл ажиллагааны дэг

5.1. Үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний хуваарийг шуурхай удирдлага, зохицуулалт хариуцсан бүтцийн нэгжийн дарга баталж, Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн дарга хяналт тавина.

5.2. Төвийн аюулгүй байдлыг төвийн дарга, жижүүрлэлтийн бүрэлдэхүүний аюулгүй байдлыг Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч хариуцна.

5.3. Жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэх алба хаагч нь төвийн даргын баталсан цагийн хуваарийн дагуу ажиллана.

5.4. Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч нь хоногийн нөхцөл байдлын мэдээг ажлын өдөр эрх бүхий албан тушаалтанд биечлэн, баяр, амралтын утсаар болон албаны цахим шуудангаар танилцуулна.

5.5. Хоногийн нөхцөл байдлын мэдээтэй танилцах эрх бүхий албан тушаалтан эзгүй байгаа тохиолдолд түүний үүргийг түр орлон гүйцэтгэж буй албан тушаалтанд танилцуулна.

5.6. Жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нь дүрэмт хувцсыг цэргийн алба  хаагчийн дүрэмт хувцас өмсөх дүрмийн дагуу өмсөж хэрэглэнэ.

5.7. Шуурхай удирдлагын байранд үүрэг гүйцэтгэх үед цэргийн дүрэмд заасны дагуу илтгэж мэдэгдэнэ.

5.8. Жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нь ажлын байранд гарсан зөрчил дутагдлын талаар тухай бүр биеэр болон утас, цахим шуудан, факсаар төвийн даргад танилцуулна.

5.9. Жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагч нь техник хэрэгсэл болон эд хогшил, бусад эд зүйлсийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

## Зургаа. Төвийн байранд хориглох зүйл

6.1. Жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын байрыг дур мэдэн түр болон удаан хугацаагаар орхин явах;

6.2. Ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, тамхи татах;

6.3. Холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах, бусдад ашиглуулах;

6.4. Шуурхай удирдлагын байранд ахуйн хэрэглээний цахилгаан хэрэгсэл ашиглах (үсний сэнс, сахлын машин, индүү, халаах, хөргөх төхөөрөмж, массажны цахилгаан хэрэгсэл гэх мэт), хэт чанга дуу чимээ гаргаж бусдын ажилд саад болох;

6.5. Жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчаар тухайн ажлын байрны тодорхойлолтод зааснаас бусад ажил, үүрэг гүйцэтгүүлэх;

6.6. Төвийн байранд эрх бүхий албан тушаалтнаас бусад хүн орох, дотоод үйл ажиллагаанд оролцох.

## Долоо. Журмын хэрэгжилтэд хяналт тавих

7.1. Энэ журмын хэрэгжилтэд шуурхай удирдлага, зохицуулалт хариуцсан дэд дарга хяналт тавьж ажиллана.

7.2. Энэ журмыг зөрчсөн алба хаагчид холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

..... o O o .....

“Гамшгийн шуурхай удирдлага, зарлан
мэдээллийн төвийн ажиллах журам”-ын
1 дүгээр хавсралт

ХОНОГИЙН МЭДЭЭНИЙ ЗАГВАР

МОНГОЛ УЛСЫН ГАМШГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ХОНОГИЙН МЭДЭЭ

Огноо Дугаар : '' гараг

НЭГ. ЦАГ АГААРЫН ТАЛААР

| | |
|---|---|
| 1.1 Өнгөрсөн хоногт:<br>1.2 Өнөөдөр:<br>Улаанбаатар хотод: | 1.3 Төлөв байдал: |

ХОЁР. ГАМШИГ, АЮУЛТ ҮЗЭГДЛИЙН ТАЛААР

| | | | |
|---|---|---|---|
| | **Мэдээний агуулга** | **Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ** | **ОБЕГ-ын даргын өгсөн үүрэг** |
| **Гамшгийн ангилал** | | | |
| **Гамшгийн төрөл** | | **Дэд төрөл** | |
| | Аймаг /хот/, сум /дүүрэг/, баг /хороо/, гудамж /байр/, тоот, газар орон байршил | | |
| | Болсон үйл явц | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | |
| | Мэдээлэл хүлээн авсан огноо: | Эхэлсэн огноо: | |
| | Хохирол:<br>Аварсан:<br>Ажилласан хүн хүч, техник: | | |

МЭДЭЭТЭЙ ТАНИЛЦСАН

| | |
|---|---|
| **Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга** | |
| **ГШУГ-ын дарга** | **ГТТГ-ын дарга** |
| **Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн тэмдэглэл** | |

ХЯНАСАН:
Албан тушаал, цол гарын үсэг овог, нэр
ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:
Албан тушаал, цол гарын үсэг овог, нэр

ХҮЛЭЭН АВСАН:
Албан тушаал, цол гарын үсэг овог, нэр

“Гамшгийн шуурхай удирдлага, зарлан
мэдээллийн төвийн ажиллах журам”-ын
2 дугаар хавсралт

## ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ:

1. мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээд. (овог нэр, утасны дугаар) ............................................
2. дуудлага өгсөн огноо /он, сар, өдөр, цаг, минут/… ...................................................................
3. тохиолдол болсон аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хороо, газар орны нэр, байршил...............
4. тохиолдол болсон огноо /он, сар, өдөр, цаг, минут/ ................… ................................................
5. бусад мэдээлэл...........................................................................................................................

Өртсөн хүний мэдээлэл

| № | Овог | Нэр | Нас | Хүйс | Төлөв (нас барсан, бэртсэн, өвчилсөн) | Үндсэн захиргаа | Хаяг | Хувь хүний онцлог байдал (хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй, согтууруулах ундаа хэрэглэсэн) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | |
| | | | | | | | | |

... АНГИ, БАЙГУУЛЛАГЫН
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАГЧ........................................../цол, овог нэр/

..... o O o .....

“Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн ажиллах журам”-ын
3 дугаар хавсралт

**ЗООНОЗЫН ХАЛДВАРТ ӨВЧИН, ДЭГДЭЛТ, ХОРДЛОГЫН ТУХАЙ МЭДЭЭ:**

1. мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээд. (овог нэр, утасны дугаар) ............................................
2. дуудлага өгсөн огноо /он, сар, өдөр, цаг, минут/…..................................................................
3. тохиолдол болсон аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хороо, газар орны нэр, байршил..............
4. тохиолдол болсон огноо /он, сар, өдөр, цаг, минут/ ................…................................................
5. голомтод байгаа иргэн, өрхийн тоо..........................................................................................
6. бусад мэдээлэл ..........................................................................................................................

Өртсөн хүний мэдээлэл

| № | Овог | Нэр | Нас | Хүйс | Төлөв (нас барсан, бэртсэн, өвчилсөн) | Үндсэн захиргаа | Хаяг | Хувь хүний онцлог байдал (хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй) | Илэрсэн шинж тэмдэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |

... АНГИ, БАЙГУУЛЛАГЫН
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАГЧ........................................../цол, овог нэр/

..... o O o .....

“Гамшгийн шуурхай удирдлага, зарлан
мэдээллийн төвийн ажиллах журам”-ын
4 дүгээр хавсралт

**МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ТУХАЙ МЭДЭЭ:**

1. мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээд. (овог нэр, утасны дугаар) ...........................................
2. дуудлага өгсөн огноо /он, сар, өдөр, цаг, минут/…...................................................................
3. тохиолдол болсон аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хороо, газар орны нэр, байршил..............
4. тохиолдол болсон огноо /он, сар, өдөр, цаг, минут/ ................…...............................................
5. мал, амьтан өвчилсөн газрын ойролцоо байгаа өрх, малын тоо …..............................................
6. мал, амьтан өвчилж эхэлсэн огноо.........................................................…..............................
7. ямар мал, амьтан өвчилсөн (бог, бод, амьтан) ..........................................................................
8. өвчилсөн мал, амьтаны тоо .........................................................................................................
9. өвчилсөн мал, амьтанд илэрсэн шинж тэмдэг.........................................................................
10. мал эмнэлгийн байгууллагад мэдэгдсэн эсэх (огноо)...............................................................
11. бусад мэдээлэл............................................................................................................................

... АНГИ, БАЙГУУЛЛАГЫН
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАГЧ.........................................../цол, овог нэр/

..... o O o .....

“Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн ажиллах журам”-ын
5 дугаар хавсралт

## ХҮЧТЭЙ ЦАСАН БОЛОН ШОРООН ШУУРГАНЫ ТУХАЙ МЭДЭЭ:

1. мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээд. (овог нэр, утасны дугаар) ..........................................
2. дуудлага өгсөн огноо /он, сар, өдөр, цаг, минут/…...................................................................
3. тохиолдол болсон аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хороо, газар орны нэр, байршил..............
4. тохиолдол болсон огноо /он, сар, өдөр, цаг, минут/ ................…...............................................
5. барилга, байгууламж, өрхөд эвдрэл, гэмтэл үүссэн байдал /анхны байдлаар/ ….....................
6. үргэлжилсэн хугацаа /цагийн баримжаагаар/ ...............................................................................
7. өртсөн малын тоо.............................................................…..................................................
8. бусад мэдээлэл....................................................................…............................................

Өртсөн хүний мэдээлэл

| № | Овог | Нэр | Нас | Хүйс | Төлөв (нас барсан, бэртсэн, өвчилсөн) | Үндсэн захиргаа | хаяг | Хувь хүний онцлог байдал (хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй, согтууруулах ундаа хэрэглэсэн) | Төөрсөн, сураггүй болсон огноо /он, сар, өдөр, цаг, минут/ | Хамгийн сүүлд хаана явж байгаад сураггүй болсон байршил (аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хороо, газар орны нэр, байршил) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |

... АНГИ, БАЙГУУЛЛАГЫН
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАГЧ........................................../цол, овог нэр/

..... o O o .....

“Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн ажиллах журам”-ын 6 дугаар хавсралт

## ҮЕРИЙН ТУХАЙ МЭДЭЭ:

1. мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээд. (овог нэр, утасны дугаар) ............................................
2. дуудлага өгсөн огноо /он, сар, өдөр, цаг, минут/…....................................................................
3. тохиолдол болсон аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хороо, газар орны нэр, байршил..............
4. тохиолдол болсон огноо /он, сар, өдөр, цаг, минут/ ................…................................................
5. үерт автсан байр, байшин, гэр /тоо/…..........................................................................................
6. үерт өртсөн малын тоо…..................................................................................................................
7. бусад мэдээлэл.................................................................................................................................

Өртсөн хүний мэдээлэл

| № | Овог | Нэр | Нас | Хүйс | Төлөв (нас барсан, бэртсэн, өвчилсөн) | Үндсэн захиргаа | Хаяг | Хувь хүний онцлог байдал (хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй, согтууруулах ундаа хэрэглэсэн) | Аварсан эсэх (тийм/үгүй) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |

... АНГИ, БАЙГУУЛЛАГЫН
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАГЧ........................................../цол, овог нэр/

..... o O o .....

“Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн ажиллах журам”-ын 7 дугаар хавсралт

## ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ТУХАЙ МЭДЭЭ:

1. мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээд. (овог нэр, утасны дугаар) ............................................
2. дуудлага өгсөн огноо /он, сар, өдөр, цаг, минут/…..................................................................
3. тохиолдол болсон аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хороо, газар орны нэр, байршил...............
4. тохиолдол болсон огноо /он, сар, өдөр, цаг, минут/ ................…..............................................
5. газар хөдлөлт болсон газрын солбицол.........................................................................................
6. иргэнд мэдрэгдсэн байдал…............................................................................................................
7. обьектод нөлөөлсөн байдал ..............................................................................................................
8. хорогдсон мал /тоо/ ...........................................................................................................................
9. бусад мэдээлэл....................................................................................................................................

Өртсөн хүний мэдээлэл

| № | Овог | Нэр | Нас | Хүйс | Төлөв (нас барсан, бэртсэн, өвчилсөн) | Үндсэн захиргаа | Хаяг | Хувь хүний онцлог байдал (хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | |
| | | | | | | | | |

... АНГИ, БАЙГУУЛЛАГЫН
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАГЧ.........................................../цол, овог нэр/

..... o O o .....

“Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн ажиллах журам”-ын 8 дугаар хавсралт

## ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМРИЙН ТУХАЙ МЭДЭЭ:

1. мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээд. (овог нэр, утасны дугаар) ...........................................
2. дуудлага өгсөн огноо /он, сар, өдөр, цаг, минут/…....................................................................
3. тохиолдол болсон аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хороо, газар орны нэр, байршил...............
4. тохиолдол болсон огноо /он, сар, өдөр, цаг, минут/ ................…...............................................
5. тухайн орон нутгаас аль зүгт, хэдэн орчим километрт...............................................................
6. солбицол........................................................................................................................................
7. тухайн нутаг дэвсгэрт хүн байгаа эсэх.........................................................................................
8. тухайн нутаг дэвсгэрт мал байгаа эсэх.........................................................................................
9. тухайн нутаг дэвсгэрт барилга, байгууламж байгаа эсэх.........................................................
10. бусад мэдээлэл..........................................................................................................................

Өртсөн хүний мэдээлэл

| № | Овог | Нэр | Нас | Хүйс | Төлөв (нас барсан, бэртсэн, өвчилсөн) | Үндсэн захиргаа | Хаяг | Хувь хүний онцлог байдал (хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй, согтууруулах ундаа хэрэглэсэн) | Өртсөн хүний биеийн байдал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |

... АНГИ, БАЙГУУЛЛАГЫН
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАГЧ............................................/цол, овог нэр/

..... о О о .....

“Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн ажиллах журам”-ын 9 дүгээр хавсралт

## ОБЪЕКТЫН ГАЛ ТҮЙМРИЙН ТУХАЙ МЭДЭЭ:

1. мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээд. (овог нэр, утасны дугаар) ...........................................
2. дуудлага өгсөн огноо /он, сар, өдөр, цаг, минут/…...................................................................
3. тохиолдол болсон аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хороо, газар орны нэр, байршил..............
4. тохиолдол болсон огноо /он, сар, өдөр, цаг, минут/ ................…...............................................
5. гал түймэрт өртсөн эд зүйлс /баримжаагаар/...................................................................…
6. хохирлын хэмжээ анхны байдлаар ....................….........................................…....................
7. бусад мэдээлэл..........................................................................................................................

Өртсөн хүний мэдээлэл

| № | Овог | Нэр | Нас | Хүйс | Төлөв (нас барсан, бэртсэн) | Үндсэн захиргаа | Хаяг | Хувь хүний онцлог байдал (хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй, согтууруулах ундаа хэрэглэсэн) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | |
| | | | | | | | | |

... АНГИ, БАЙГУУЛЛАГЫН
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАГЧ.........................................../цол, овог нэр/

..... o O o .....

“Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн ажиллах журам”-ын
10 дугаар хавсралт

## ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ОСЛЫН ТУХАЙ МЭДЭЭ:

1. мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээд. (овог нэр, утасны дугаар) ..........................................
2. дуудлага өгсөн огноо /он, сар, өдөр, цаг, минут/…..................................................................
3. тохиолдол болсон аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хороо, газар орны нэр, байршил...............
4. тохиолдол болсон огноо /он, сар, өдөр, цаг, минут/ ………………................................................
5. тухайн орон нутгаас аль зүгт, хэдэн орчим километрт………………………………………………......
6. автотехникийн болон тээврийн хэрэгслийн загвар, улсын дугаар, зориулалт, хүн тээврийн, ачааны, шатахууны, тээвэрлэгч гэх мэт…........................................
7. бусад мэдээлэл.........................................................................................................................

Өртсөн хүний мэдээлэл

| № | Овог | Нэр | Нас | Хүйс | Төлөв (нас барсан, бэртсэн) | Үндсэн захиргаа | Хаяг | Хувь хүний онцлог байдал (хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй) | Өртсөн хүний биеийн байдал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |

... АНГИ, БАЙГУУЛЛАГЫН
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАГЧ........................................../цол, овог нэр/

..... o O o .....

“Гамшгийн шуурхай удирдлага, зарлан
мэдээллийн төвийн ажиллах журам”-ын
11 дүгээр хавсралт

## ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ХОЛБОГДОЛТОЙ ОСЛЫН ТУХАЙ МЭДЭЭ:

1. мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээд. (овог нэр, утасны дугаар) ..........................................
2. дуудлага өгсөн огноо /он, сар, өдөр, цаг, минут/…....................................................................
3. тохиолдол болсон аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хороо, газар орны нэр, байршил...............
4. тохиолдол болсон огноо /он, сар, өдөр, цаг, минут/ ................…...............................................
5.ямар осол болсон тухай.......................
6. үйл ажиллагааны чиглэл.....................................................................................................
7. бусад мэдээлэл.......................................................................................................................

Өртсөн хүний мэдээлэл

| № | Овог | Нэр | Нас | Хүйс | Төлөв (нас барсан, бэртсэн) | Үндсэн захиргаа | Хаяг | Хувь хүний онцлог байдал (хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй) | Өртсөн хүний биеийн байдал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |

... АНГИ, БАЙГУУЛЛАГЫН
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАГЧ........................................../цол, овог нэр/

..... o O o .....

“Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн ажиллах журам”-ын
12 дугаар хавсралт

## УУЛ УУРХАЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ХОЛБОГДОЛТОЙ ОСОЛ:

1. мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээд. (овог нэр, утасны дугаар) ..........................................
2. дуудлага өгсөн огноо /он, сар, өдөр, цаг, минут/…...................................................................
3. тохиолдол болсон аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хороо, газар орны нэр, байршил..............
4. тохиолдол болсон огноо /он, сар, өдөр, цаг, минут/ ...................................................................
5. үйл ажиллагааны чиглэл.................................................................................................................
6. аюул, ослын төрөл..........................................................................................................................
6. бусад мэдээлэл...............................................................................................................................

Өртсөн хүний мэдээлэл

| № | Овог | Нэр | Нас | Хүйс | Төлөв (нас барсан, бэртсэн) | Үндсэн захиргаа | Хаяг | Хувь хүний онцлог байдал (хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй) | Өртсөн хүний биеийн байдал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |

... АНГИ, БАЙГУУЛЛАГЫН
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАГЧ........................................../цол, овог нэр/

..... о О о .....

“Гамшгийн шуурхай удирдлага, зарлан
мэдээллийн төвийн ажиллах журам”-ын
13 дугаар хавсралт

## ЦАЦРАГ ИДЭВХТ БОЛОН ХИМИЙН ХОРТ БОДИСЫН ОСЛЫН ТУХАЙ:

1. мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээд. (овог нэр, утасны дугаар) ..........................................
2. дуудлага өгсөн огноо /он, сар, өдөр, цаг, минут/…..................................................................
3. тохиолдол болсон аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хороо, газар орны нэр, байршил...............
4. тохиолдол болсон огноо /он, сар, өдөр, цаг, минут/ ................…...............................................
5. ослын төрөл.....................................................................................................................................
6. байгууллагын нэр, үйл ажиллагааны чиглэл.................................................................................
7. бусад мэдээлэл................................................................................................................................

Өртсөн хүний мэдээлэл

| № | Овог | Нэр | Нас | Хүйс | Төлөв (нас барсан, бэртсэн) | Үндсэн захиргаа | Хаяг | Хувь хүний онцлог байдал (хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй) | Өртсөн хүний биеийн байдал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |

... АНГИ, БАЙГУУЛЛАГЫН
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАГЧ........................................../цол, овог нэр/

..... o O o .....

“Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн ажиллах журам”-ын
14 дүгээр хавсралт

## ТЭСЭРЧ, ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ОСЛЫН ТУХАЙ:

1. мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээд. (овог нэр, утасны дугаар) ...........................................
2. дуудлага өгсөн огноо /он, сар, өдөр, цаг, минут/…....................................................................
3. тохиолдол болсон аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хороо, газар орны нэр, байршил...............
4. тохиолдол болсон огноо /он, сар, өдөр, цаг, минут/ ................…...............................................
5. байгууллагын нэр, үйл ажиллагааны чиглэл..................................................................................
6. юу тэсэрч, дэлбэрсэн талаар.........................
7. хэдий хэмжээний тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл байгаа эсэх / баримжаагаар/
8. бусад мэдээлэл..................................................................................................................................

Өртсөн хүний мэдээлэл

| № | Овог | Нэр | Нас | Хүйс | Төлөв (нас барсан, бэртсэн) | Үндсэн захиргаа | Хаяг | Хувь хүний онцлог байдал (хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй) | Өртсөн хүний биеийн байдал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |

... АНГИ, БАЙГУУЛЛАГЫН
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАГЧ.........................................../цол, овог нэр/

..... o O o .....

“Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн ажиллах журам”-ын 15 дугаар хавсралт

**АХУЙН ОСОЛ:**

1. мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээд. (овог нэр, утасны дугаар) ..........................................
2. дуудлага өгсөн огноо /он, сар, өдөр, цаг, минут/…....................................................................
3. тохиолдол болсон аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хороо, газар орны нэр, байршил..............
4. тохиолдол болсон огноо /он, сар, өдөр, цаг, минут/ ................…...............................................
5. байгууллагын нэр, үйл ажиллагааны чиглэл..................................................................................
6. бусад мэдээлэл.................................................................................................................……

Өртсөн хүний мэдээлэл

| № | Овог | Нэр | Нас | Хүйс | Төлөв (нас барсан, бэртсэн) | Үндсэн захиргаа | Хаяг | Хувь хүний онцлог байдал (хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй) | Өртсөн хүний биеийн байдал / ямар байдлаар осолд өртсөн / |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |

... АНГИ, БАЙГУУЛЛАГЫН
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАГЧ........................................../цол, овог нэр/

..... o O o .....

“Гамшгийн шуурхай удирдлага, зарлан
мэдээллийн төвийн ажиллах журам”-ын
16 дугаар хавсралт

ИРСЭН МЭДЭЭНИЙ БҮРТГЭЛ

| д/д | Аль газар, хэлтсээс ирсэн | Мэдээний дугаар | Мэдээний утга | Он, сар,өдөр, цаг, минут | Дуудлага хүлээн авагчийн цол, нэр | Хэнд танилцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | | | | | | |
| 2 | | | | | | |
| 3 | | | | | | |
| 4 | | | | | | |
| 5 | | | | | | |
| 6 | | | | | | |
| 7 | | | | | | |
| 8 | | | | | | |
| 9 | | | | | | |
| 10 | | | | | | |
| 11 | | | | | | |
| 12 | | | | | | |
| 13 | | | | | | |
| 14 | | | | | | |
| 15 | | | | | | |
| 16 | | | | | | |
| 17 | | | | | | |
| 18 | | | | | | |
| 19 | | | | | | |
| 20 | | | | | | |

ИЛГЭЭСЭН МЭДЭЭНИЙ БҮРТГЭЛ

| д/д | Аль газар, хэлтсээс илгээсэн | Мэдээний дугаар | Мэдээний утга | Он, сар, өдөр, цаг, минут | Дуудлага хүлээн авагчийн цол, нэр | Хүлээн авсан газар, хэлтэс |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | | | | | | |
| 2 | | | | | | |
| 3 | | | | | | |
| 4 | | | | | | |
| 5 | | | | | | |
| 6 | | | | | | |
| 7 | | | | | | |
| 8 | | | | | | |
| 9 | | | | | | |
| 10 | | | | | | |
| 11 | | | | | | |
| 12 | | | | | | |
| 13 | | | | | | |
| 14 | | | | | | |
| 15 | | | | | | |
| 16 | | | | | | |
| 17 | | | | | | |
| 18 | | | | | | |
| 19 | | | | | | |
| 20 | | | | | | |

“Гамшгийн шуурхай удирдлага, зарлан
мэдээллийн төвийн ажиллах журам”-ын
17 дугаар хавсралт

ГАМШГИЙН ГОЛОМТОД АШИГЛАЖ БАЙГАА ХОЛБООНЫ
ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ

<table>
<tr><th rowspan="3">д/д</th><th rowspan="3">Аймаг, сум, газар орны нэр</th><th rowspan="3">Он, сар, өдөр</th><th rowspan="3">Холбоочин</th><th colspan="9">Холбоо зохион байгуулалт</th></tr>
<tr><th rowspan="2">Байршил тогтоогч /марк, тоо ширхэг/</th><th rowspan="2">Солбилцол</th><th rowspan="2">Сансрын холбооны иридиум утасны дугаар</th><th rowspan="2">Үүрэн телефоны утас /хүний нэр/</th><th colspan="2">Богино долгионы радио станц /марк, тоо ширхэг/</th><th colspan="2">Хэт богино долгионы радио станц /марк, тоо ширхэг/</th></tr>
<tr><th>Суурин</th><th>Үүргэвчийн</th><th>Машины</th><th>Гар</th></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>

БҮРТГЭЛ ХӨТӨЛСӨН:
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАГЧ,

*................../ цол/....................../гарын үсэг /...................  / овог, нэр/*

..... o O o .....